



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/Н

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэд эцэг, эхийн зөвлөл байгуулж ажиллуулах зөвлөмж”-ийн 3.1.3-ийн 1, 5.1, 5.2 дахь хэсэг, “Ажлын хороо байгуулах тухай” аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/600 дугаар захирамжийн 3 дахь заалт, “2023 оны төсөв батлах тухай” сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 11/03 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх зорилтот жилийн нээлтийн үйл ажиллагааны зардалд 810,600 (найман зуун арван мянга зургаан зуу) төгрөг, хамтарсан багийн бичиг хэргийн зардалд 248,000 (хоёр зуун дөчин найман мянга) төгрөг, Ахмадын хорооны үйл ажиллагааны зардалд 300,000 (гурван зуун мянга) төгрөг, байгууллагын хүүхдийн өрөө тохижуулах зардалд 286,500 (хоёр зуун наян зургаан мянга таван зуу) төгрөг, нийт 1,645,100 (нэг сая зургаан зуун дөчин таван мянга нэг зуу) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 1,645,100 (нэг сая зургаан зуун дөчин таван мянга нэг зуу) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын бараа, үйлчилгээний бусад зардлаас зарцуулахыг нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.



ДАРГА

Н.БАТ-ЭРДЭНЭ